

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Нийслэл, дүүргийн төсвийн тодотголын бэлтгэлийг ажлыг сайтар хангаж ажиллах.				
1	Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын 4/1638, 4/1639 тоот албан бичгүүдийг дүүргийн боловсролын 57 байгууллага, орон нутгийн төсвийн 12 байгууллагад тус тус хүргүүлж, судалгаа тооцоог авч нэгтгэн, нийслэлийн төрийн сан болон дүүргийн татварын албатай хамтран ажиллаж тодотголын тооцоог хийж байна.			
Үүрэг даалгавар ХОЁР: Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/378 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын уялдаагаа, хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажиллах				
2	<p>Чингэлтэй Хөрөнгө Оруулалт Бүтээн Байгуулалтыг Дэмжих Төвөөс Нийслэлийн Засаг даргын 2023 оны Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхээр дараах ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Чингэлтэй дүүргийн Авто баазын барилгын “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Дүүргийн авто баазын барилга” ажлын гүйцэтгэгчээр “НУМТ-ӨРГӨӨ” ХХК 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдөр эхэлж 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдөр ашиглалтад өгөхөөр; ➢ Дүүргийн ЕБ-ын 61 дүгээр сургуулийн “Урлаг соёлын заалыг засварлах” ажлын гүйцэтгэгчээр ТЕГАТЕРА ТЕХ” ХХК 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр эхэлж 2023 оны 07 дугаар сарын 01-нд ашиглалтад оруулахаар; ➢ Дүүргийн 3 дугаар хорооны “Хүүхдийн тоглоомын талбайн засвар”-н ажил, 18 дугаар хорооны Яргайт 43 дугаар гудамж сайжруулах ажлын гүйцэтгэгчээр “АЙ ЭМ ДИ” ХХК 2023 оны 07 дугаар сарын 01-нд ашиглалтад оруулахаар; ➢ Дүүргийн 15 дугаар хороо Жаргалантын 36 дугаар гудамж сайжруулах ажлыг “Гоц Тех Инженеринг” ХХК тус тус гүйцэтгэж байна. <p>ТНААХ</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Гэр хорооллын дундах авто замын дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх” төсөл арга хэмжээг “Ди Вай Кэй” ХХК хэрэгжүүлэн ажиллаж байна. Газар чөлөөлөлтийн нөхөн олговор шийдвэрлэгдээгүйгээс ажил зогсонги байдалтай байна.</p> <p>- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Дэнжийн 1000-ын Цагаан байрны уулзвараас Хүчит шонхор захын уулзвар хүртэлх туслах замын өргөтгөл” төсөл арга хэмжээг “Экспресс зам” ХХК хэрэгжүүлэн ажиллаж байна. Ажлын явц хэвийн үргэлжилж байна.</p>			

	- Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар "Гудамж сайжруулах ажил-15 дугаар хороо" төсөл арга хэмжээг "Гоц тех инженеринг" ХХК хэрэгжүүлэн ажиллаж байна.			
Үүрэг даалгавар ГУРАВ: Дүүргүүд нийслэлд төвлөрүүлэх төсвийн орлогын биелэлтийг жигд хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.				
3	<p>СТСХ</p> <p>Дүүргийн төсвөөс Нийслэлийн төсөвт 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 57,870.2 сая төгрөг шилжүүлэхээс 53,225.2 сая төгрөг шилжүүлж 92 хувийн биелэлттэй, 6 дугаар сарын хуваарийн дагуу төвлөрүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Татварын хэлтсээс 6 дугаар сарын дүнгээр:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Улсын төсөв:75%, Нийслэлийн төсөв:82%, Дүүргийн төсөв:35% нийт 62% гүйцэтгэлтэй байна. <p>Өссөн дүнгээр:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Улсын төсөв:115%, Нийслэлийн төсөв:89%, Дүүргийн төсөв:90% нийт дүнгээр 95.4% гүйцэтгэлтэй байна. <p>Татварын төрөл бүрээр өрийн судалгаа гарган өмнөх оны болон тайлант оны өртэй татвар төлөгчдийн "и-майл" хаяг болон утасны дугаарт мэдэгдэл хүргүүлэх, гэрийн хаягийг тодруулж шуудангаар нэхэмжлэл хүргүүлэх, өр барагдуулах нэхэмжлэхийн хугацаанд төлөлт хийгээгүй татвар төлөгчийн арилжааны банкин дахь харилцах дансны гүйлгээг хаах зэрэг арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.</p>			
Үүрэг даалгавар ДӨРӨВ: Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд хийгдэж байгаа авто зам, явган хүний замын засвар, шинэчлэл, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх болон худалдаа үйлчилгээ гаргах зэрэг ажлууд эрчимжүүлж ажиллах				
4	<p>ТНААХ</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэр дэх авто замын нүхэн эвдрэлийг засварлах ажлыг "Экспресс зам" ХХК, "Квадровэй" ХХК гүйцэтгэн ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд нийт 8000м2 явган зам хийж гүйцэтгэхээр одоогийн байдлаар 4 байршилд явган замын ажлыг дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийж гүйцэтгэж байна.</p>			
Үүрэг даалгавар ТАВ: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 21/06 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсээс мал бүхий иргэдийг гаргах ажлыг тогтмол зохион байгуулах.				
5	<p>Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 21/06 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/35 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Чингэлтэй дүүргийн ЗД-ын 2023 оны "Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал орж ирэхээс урьдчилан сэргийлэх тухай" А/27 дугаар захирамж, удирдамжийг гаргуулан ЗДТГ-ын Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс, санхүү төрийн сангийн хэлтэс, Цагдаагийн 2 хэлтсийн Зуслан дахь тасаг, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, 16-24 дүгээр хорооны ажлын албаны бүрэлдэхүүнтэй хамтран 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал нэвтэрч орж ирсэн малыг гаргах ажлыг зохион байгуулсан. Захирамжаар шаардагдах 6,429,500 төгрөгийг шийдвэрлүүлж 12 өдрийн хамтарсан хяналт шалгалтыг хийж ажлын хэсэг 4 удаа</p>			

хуралдаж 4690 тооны адуу малыг дүүргийн нутаг дэвсгэрээс гаргаж 12 иргэнээс хориглосон бүсэд мал амьтан оруулахгүй байх баталгааг гаргуулан 3 иргэнд Зөрчлийн тухай хуулиар нийт 750,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх журам” батлах тухай 85 дугаар тогтоол, 2019 оны “Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх буюу хориглох бүсийн хил хязгаарыг шинэчлэн батлах тухай” 21/06 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд байгаа мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх тухай” А/578 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/35, Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/27 дугаартай захирамжуудын хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан.

Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хороодын нутаг дэвсгэр, Нийслэлийн ногоон бүс болох Зусланд адуу мал орж ирэхээс урьдчилан сэргийлэх эргүүл хяналт шалгалтыг өдөр бүр албаны 54-81 УАК улсын дугаартай “УАЗ ХАНТЕР” маркийн автомашинаар 5 хүний бүрэлдэхүүнтэй баг, хороодын засаг дарга нар хариуцсан хорооны нутаг дэвсгэрт томилгоот алба хаагчдыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 01 ний өдрийг хүртэлх хугацаанд ажиллуулан, долоо хоногийн мягмар, баасан гарагуудад иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, мал, амьтны гаралтай гоц халдварт өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй хамтран 2500 км замыг 450 литр шатахуун зарцуулж 5100 тооны адууг хариуцсан нутаг дэвсгэрээс гаргах ажлыг зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд хариулгагүй адуугаа хориглосон бүсэд оруулсан дараах иргэдийн адууг эм тамга, содон шинж тэмдгээр нь хэний адуу болохыг олж тогтоон адуугаа зөвшөөрөгдсөн бүсэд гаргуулах зорилгоор мэдэгдэл шаардлагыг хүргүүлэн ажилласан Үүнд:

- Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Тахилт орчимд орж ирсэн адууг шалгаж Баянзүрх дүүргийн иргэн Ц.Ганбаатарын 8 азарга 110 тооны адуу болохыг тогтоон эзэнд нь хүлээлгэн өгч хориглосон бүсээс адуугаа гаргах №20230111 дугаартай шаардлага өгсөн. / холбогдох утас:86111223 /
- Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо “Хоймор Хайрхан” амралтын орчимд өдөр бүр орж ирдэг гэх Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Өлийн амны 15 тоотод оршин суух хаягтай иргэн Т.Ононгийн эзэмшлийн 1 азарга, 230 тооны адуу болохыг тогтоон эзэнд нь хүлээлгэн өгч № 20230112 дугаартай шаардлага өгсөн. / холбогдох утас 91160721 /
- Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо Жигжид зуслан орчимд Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Партизаны задгайд хаягтай иргэн Б.Ганзоригийн адуу орж ирдэг болохыг тогтоон хориглосон бүсээс адуугаа гаргах дахин оруулахгүй байхыг анхааруулж №20230113 дугаартай шаардлага өгч Гүнтийн даваагаар мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөгдсөн бүс рүү гаргаж ажилласан.
- Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо Хоршооллын 10-22 тоотод суух “88760027” дугаарын

<p>уастай иргэн Д.Дашзэвэг /эрлийз хээр азаргатай 32 тооны адуу, хэвтээ нуман тамгатай болохыг тогтоон № /202214024 / дугаартай шаардлага өгч адууг нь гаргасан.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Ар гүнтийн задгай тоотод суух Б.Гантөмөр шарга, халтар азаргатай /60 орчим тооны адуу/ №202214026 дугаартай шаардлага өгч адууг нь гаргасан. ➤ Баянгол дүүргийн 8 дугаар хороо 11в-16 тоотод суух иргэн Б.Болдтоогоо “89118174 ” дугаарын уастай / 48 тооны адуутай, ширээтэй гурван гал тамгатай болохыг тогтоон / 202214028 / дугаартай шаардлага өгч адууг гаргасан. ➤ .Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо “Ар-Гүнт”- ийн задгай тоотод суух “91618780” дугаарын уастай Г.Ганбат / 58 адуутай, нэмэхтэй дөл тамгатай болохыг тогтоон / 202214029 / дугаартай шаардлага өгч адууг гаргасан ➤ .Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо 3-2196 тоотод суух “89874214” дугаарын уастай Д.Пропуск / 95 адуутай, саран дэвсгэртэй дэгээ тамгатай / болохыг тогтоон / 202214030 / дугаартай шаардлага өгч адууг гаргасан. ➤ Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо Цэргийн хотхон 4-304 тоотод суух Д.Жаргалсайхан / 30 адуутай, сэнжтэй саран тамгатай болохыг тогтоон / 202214031/ дугаартай шаардлага өгч адууг гаргасан. ➤ Сонгино-Хайрхан дүүргийн 20 дугаар хороо 2 хэсэг тоотод оршин суух Ш.Хүдэрчулуун / 3 азарга 100 орчим тооны “88034844” дугаарын уастай нум сум, нар саран тамгатай болохыг тогтоон / 20230101/ дугаартай шаардлага өгч адууг гаргасан. ➤ Сонгино-Хайрхан дүүргийн 21 дүгээр хороо Аюушийн 7-1 тоотод оршин суух хаягтай “90189146” дугаарын уастай иргэн Хүдэрчулуунд /20230102/ шаардлага өгч адууг гаргасан. ➤ Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо 1 гудамж тоот хаягтай Б.Төмөр-Чөдөр “86589997” дугаарын уастай болохыг тогтоон /20230103/ дугаартай шаардлага өгч гаргасан. ➤ Сонгино-Хайрхан дүүргийн 2 дугаар хорооны хаягтай Ц.Найдандорж /20230104/ нарт албан мэдэгдлүүдийг өгч адуугаа суурьшлын бүсээс гаргуулан хориглосон бүсэд дахин адуу малаа оруулж ирэхгүй байх талаар баталгаа бичүүлэн авч хяналт тавин ажиллаж байна. <p>Хориглосон бүсэд адуугаа оруулахгүй байх баталгаа гаргасан 12 иргэнээс удаа дараа адуугаа хориглосон бүсэд оруулсан, Цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй зөрчил гаргасан Баян зүрх дүүргийн 9 дүгээр хорооны 4-68 тоотод оршин суух хаягтай Дашпунцаг овогтой Дашзэвгэ, Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо 4-304 тоотод оршин хорооны нутаг дэвсгэрт оршин суух хаягтай Отгонбаярын Гантөмөр нарт зөрчлийн тухай хуулийн 15.2-р зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 д заасны дагуу тус бүрийг 250,000 мянган төгрөг нийт 750,000 мянган төгрөгөөр торгож адуугаа хориглосон бүсээс авч гаргах, дахин оруулж ирэхгүй байх талаар баталгаа бичүүлэн адууг нь хүлээлгэн өгснөөр хариуцсан бүсэд одоогоор адуугаа оруулаагүй байна.</p>			
---	--	--	--

Үүрэг даалгавар ЗУРГАА: Автозамын хайс, хашлага, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу будаж, засварлах ажлыг эрчимжүүлж ажиллах.

6	ТНААХ			
---	-------	--	--	--

	Нийслэлийн авто замын хөгжлийн газраас дүүргийн 14, 18 дугаар хорооны Чингэлтэйн өргөн чөлөө, 15, 16 дугаар хорооны Хайластын гудамж, 12 дугаар хороо Дэнжийн мянгын авто зам дагуу нийт 300у/м хайс хашлага, 7 тэмдэг, 350у/м тэмдэглэгээг тус тус хийж гүйцэтгээд байна.			
Үүрэг даалгавар ДОЛОО: Хан-Уул дүүргийн Ар Зайсангийн гудамжнаас “Дугуй цагаан”-ны тохижилтын ажлуудыг эрчимжүүлж 07 дугаар сарын 01-нд нээх болон нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ажлын чанар, стандартад хяналт тавьж ажиллах.				
7	<p>Дүүргийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт, цэнэг усалгааг Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК хариуцан ажилладаг ба нийт 72857м2 талбайн цэвэрлэгээ арчилгааг өдөр тутамдаа хариуцан 138 рейсээр 1380 тонн усаар хаврын цэнэг усалгаа, мод бутны ургалт сайжруулах зорилгоор 863 ширхэг мод, бутны тогоо, 220 у/м ургамлан хашлаганд шуудуу гаргах, 233 ширхэг модыг шохойдож ажилласан.</p> <p>Мөн ногоон байгууламжийн ажилбарууд 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хариуцан ажиллаж буй бичил цэцэрлэгүүд болон нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн ногоон байгууламжит гудамж талбайд эхлэн дараах ажилбаруудыг хийж, гүйцэтгэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ 484 ширхэг улиас болон хайлаас хэлбэржүүлэлт, 1684у/м ургамлан хашлага хэлбэржүүлэлт, ➢ 233 ширхэг улиас болон хайлаас модны шохойдолт, ➢ Мод, бут сөөгийн ургалтыг сайжруулах үүднээс 918 ширхэг модонд тогоо гаргах, 220 у/м ургамлан хашлагад усалгааны шуудуу гаргалт ➢ 1960 тн усаар хаврын цэнэг усалгаа болон бордоот усалгаа, ➢ Ногоон байгууламжит талбайн хамгаалалтын хайс хашлага 22 у/м, 29ш шон, 140 у/м тросс засварлах ажил ➢ Арчилгаа шаардлагатай байршлуудын ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг тогтмол хийж гүйцэтгэх, 655 ширхэг модны шуулт, хатсан модны мөчир цэвэрлэх, цэвэрлэгээнээс гарсан 126тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн ажиллаж байна. 			

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ